



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 0/303

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихэээр батлагдсан Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтоолцоог хэрэгжүүлэх /Бүрэнтотгох, Түнэл сум/ ХӨАОНӨГ/202312004 дугаартай тендерт 79,900.000 (Далан есөн сая есөн зуун мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо”--ны тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” ХХК-ийн гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, зөвлөх үйлчилгээний гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээ дүгнэх чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр Хүнс Хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны дарга (Б.Бямбасүрэн)-г томилж, зөвлөх үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбасүрэн (Аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Д.Чинзориг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

А.Энхжаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргааны байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)

Д.Бурмаа (Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал)

Ажлын хэсгийн нарийн бичиг: Х.Сайнбуян (Аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны мэргэжилтэн)

3. Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтоолцоог хэрэгжүүлэх /Бүрэнтотгох, Түнэл сум/ зөвлөх үйчилгээ худалдан гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Бямбасүрэн)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-

ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, зөвлөх үйлчилгээ хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Даваасамбуу)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

